



**МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ**  
Төрийн Өмчит Хувьцаат Компани

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар A/28

Улаанбаатар хот

### Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын тээврийн түр тариф батлах тухай

Төмөр замын тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 18 дугаар зүйлийн 18.3.3, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.11, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 тоот албан даалгаврын 9.13, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 645 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшинг баталсан тогтоол, 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаартай тээвэр эхлүүлэх тухай тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус компанийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын зүгшрүүлэлтийн тооврийн үйл ажиллагааны ачаа тээвэрлэлтийн түр тариф хэрэглэх дүрмийг хавсралтаар баталж 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын зүгшрүүлэлтийн тээврийн үйл ажиллагаанд батлагдсан дүрмийг мөрдөж ажиллахыг Тээвэр, логистикийн газрын дарга Б.Хүдэрхүүд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шалгалтын газрын дарга М.Амарсайхан, Санхүү, эдийн засгийн газрын дарга Б.Энэрэлт нарт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.БАТНАСАН

2022000145

"Монголын Төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын  
2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн  
АХЗ дугаар тушаалын хавсралт



## “МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТҮР ТАРИФ ХЭРЭГЛЭХ ДҮРЭМ

1. Энэхүү түр тарифыг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн тээвэрлэлт хийж гүйцэтгэх хугацаанд вагоны болон чингэлгээр ачаа тээвэрлэсний болон бусад ажил үйлчилгээ үзүүлсний хөлсийг бодож тооцоо хийхэд хэрэглэнэ. Дараах ажил үйлчилгээний тарифуудад НӨАТ ороогүй болно.
2. Тарифын зайг дараах хүснэгтээр тодорхойлно.

№	Өртөө зөрлөгийн нэр	Байрлал, км	Хоорондын зай, км
1	Цогц цэций өртөө	416.1	418.1
2	Зүүнбаян өртөө	0	

Тавантолгой-Зүүнбаян өртөөнөөс Зүүнбаян өртөөнд нийлэх цэгээс Зүүнбаян өртөөний тэнхлэг хүртэл 2 км зайтай.

### 3. Ачааны нэр

Ачаа илгээгч нь ачааны нэрийг тодорхойлох уялдуулсан систем (Ачааны нэрсийн жагсаалт)-д заагдсан ачааны нэрстэй тохируулан ачаагаа нэрлэж, кодыг падаанд бичнэ. Ачааны нэрийг хураангуйлах буюу дутуу бичиж болохгүй.

Ачааны нэр дутуу буюу тодорхой бус байвал ачаа илгээх өртөөнд ачааны нэрийг илгээгч тодотгоно. Ачааны нэрийг тодруулж өгөх хүртэл уг ачааг тээвэрлэгч тээвэрлэлтэд хүлээн авахгүй байж болно. Ачааны нэрийг тодруулах хүртэлх гарсан зардлыг ачаа илгээгч хариуцна.

Ачааны нэр тодорхой бус байгаа нь хүрэх өртөөнд илэрсэн тохиолдолд зөрчлийг ачаа илгээгч зөрчил илрүүлсэн өртөөтэй хамтран шийдвэрлэх бөгөөд үүнтэй холбоотой зардлыг ачаа илгээгч бүрэн хариуцна.

### 4. Ачааны жин

Тээврийн хөлсийг бодохыг тулд ачааны жинг дараах байдлаар бүхэлчилнэ.

А. Нэг бүлэгт хамааруулсан хэд хэдэн төрлийн ачааг нэг төрлийн ачаа гэж тэдний нийт жинг бүхэл тоонд дэвшүүлэн тооцно.

Б. Ачааны баглаа боодол, тавиур болон бусад хэрэгслийг ачааны нийт жинд оруулж тооцно.

### 5. Ачааны тээврийн хөлс бодох

Тээвэрлэх ачааны тээврийн хөлсийг тээврийн хөлс бодох 1 тонн/км болон -ээр тодорхойлов.

Вагон илгээлтийн тээврийн хөлсийг падаанд заасан ачааны нэр, тээвэрлэлтийн зайг үндэслэн энэхүү тарифын дагуу тооцно.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тариф	418.1 км зайд
1	Ачаатай тээврийн хөлс /төгрөгөөр/	1 тн.км	99,87	41,755.64
2	Хоосон чингэлэг тээврийн хөлс /төгрөгөөр/	1 чингэлэг тутам		281,940



Хувийн эзэмшлийн вагоноор тээвэр хийхэд хөлсийг тооцох аргачлал

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тариф	418.1 км зайд
1	Ачаатай тээврийн хөлс /төгрөгөөр/	1 тн.км	84,88	35,488.33
2	Хоосон вагоны тээврийн хөлс /төгрөгөөр/	1 вагон/км	550	229,955
3	Хоосон чингэлэг тээврийн хөлс /төгрөгөөр/	1 чингэлэг тутам		242,199

Ачаатай тээврийн тариф нь 0,035 ам.доллар байх ба төлбөрийг тээвэрлүүлэгч нь төгрөгөөр төлнө. Ам.долларыг тухайн сар бүрийн эхний өдрийн Монгол банкны ханшаар шинэчлэн төгрөгт шилжүүлэн тооцно.

6. Ажил үйлчилгээний хөлс /Дараах хүснэгтээр тодорхойлно/

№	Үзүүлэлт	Тайлбар	Хөлс
1	Вагон пүү	Вагон тутмаас	22,420
2	Хаяг солилт	Вагон тутмаас	40,000
2.1		Чингэлэг тутмаас	20,000
3	Мэдэгдэл	Утсаар	500
3.1		Цахим	300
4	Тавилт таталт	Зүтгүүр гаралт бүрд /1 км тутамд/	15,340
5	Дахин сэлгээ	1 цагт	65,000
6	Тээврийн бичиг баримт бүрдүүлэлтийн хөлс	Илгээлт тутамд	235
6.1	<i>Падааны маягт:</i>	Орон нутгийн	235
6.1.1		Олон улсын	590
6.2	<i>Элдэв хураамж</i>		118
6.3	<i>Ломбоны үнэ</i>		1,000
7	Зам талбай ашиглалтын хөлс	Вагон-хоног	20,000
8	Ачилт, буулгалтын талбай ашиглалтын хөлс	м <sup>2</sup>	175
9	Талбайгаас өөрөө явагч авто өргүүрээр /калмар/ биг-бэг ууттай ачаа техник, тоног төхөөрөмж, төмөр бетон эдлэл, бүх төрлийн төмөр, түүгээр хийсэн бүтээгдэхүүн ачиж буулгах	1 тн тутмаас	4,700
10	Шилжүүлэн ачилтын хөлс /Авто машинаас вагонд/		
10.1	Өөрөө явагч авто өргүүрээр /калмар/ вагонд ачиж буулгах		
11	Чингэлэг ачилт буулгалт /Талбайгаас калмараар/		
11.1	20 фут	Чингэлэг тутмаас	11,000/11,000
11.2	30 фут	Чингэлэг тутмаас	16,500/16,500
11.3	40 фут	Чингэлэг тутмаас	22,000/22,000
11.4	Хоосон чингэлэг ачиж буулгалтын хөлсийг 50% бууруулна.		
12	Чингэлэг зөөвөр /Талбайд/		

12.1	20 фут	Чингэлэг тутмаас	22,000
12.2	30 фут	Чингэлэг тутмаас	33,000
12.3	40 фут	Чингэлэг тутмаас	44,000
12.4	Талбайд хоосон чингэлэг хадгалах		
12.4.1	10-20 фут	Чингэлэг тутмаас	5,000
12.4.2	20-30 фут	Чингэлэг тутмаас	6,000
12.4.3	30-40 фут	Чингэлэг тутмаас	7,000
12.4.4	40 фут-с дээш	Чингэлэг тутмаас	8,000
13	Вагон ашиглалт "МТЗ" ТӨХК паркын вагон цаг тутмаас	1 хоногт	900
13.1		2-4 хоногт	3,100
13.2		5-7 хоногт	4,200
13.3		8-с дээш	6,100
14	Задгай талбайд хадгалбал /ачааны цэвэр жингийн тонн тутмаас/	хоногт тутамд	500
14.1	Ачаатай чингэлэг хадгалах		
14.1.1	10-20 фут	хоногт тутамд	10,000
14.1.2	20-30 фут	хоногт тутамд	12,000
14.1.3	30-40 фут	хоногт тутамд	14,000
14.1.4	40 фут-с дээш	хоногт тутамд	16,000
15	Вагон цэвэрлэгээний хөлс	вагон тутмаас	20,000
16	Чингэлэг цэвэрлэгээний хөлс		
16.1	10-20 фут	чингэлэг тутмаас	8,200
16.2	20-30 фут	чингэлэг тутмаас	12,400
16.3	30-40 фут	чингэлэг тутмаас	16,400
16.4	40 фут-с дээш	чингэлэг тутмаас	18,600
17	"МТЗ" ТӨХК эзэмшлийн вагоноор хангасны хөлс	вагон хоног тутмаас	50,000
18	Ачааны хашаанд автомашин орох хураамж	машин тутмаас	5,000
19	Талбайн цэвэрлэгээний хураамж	машин тутмаас	5,000

---oOo---